



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 03/47

Баян-Өндөр сум


Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байршил,
үйлчлэх хүрээг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байршил, үйлчлэх хүрээг хавсралтаар баталсугай.

2.Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байршил, үйлчлэх хүрээг батлагдсан хязгаарт багтаан тогтоож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН БАЙРШИЛ, ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

Д/д	Өрхийн эрүүл мэндийн төвийн нэр	Байршил	Харьяалах баг
1	Анхны Оч	Хүрэнбулаг баг, 4-р микр 25-р байрны ард, өөрийн байранд	Хүрэнбулаг баг
		Зэст багийн байрны 2 давхар	Зэст баг
2	Шинэ өрхийн эрүүл мэндийн төв - 1	Уртбулаг баг, 5-р микр 17-р байрны ард	Уртбулаг баг Бүрэнбүст баг
3	Мэндцэцэн	Уурхайчин баг, 3-р микр 9-р байрны ард, өөрийн байранд	Согоот баг Уурхайчин баг
4	Шинэ өрхийн эрүүл мэндийн төв - 2	Оюут баг, 2А хорооллын ард	Оюут баг
5	Мөнхсүндэрэл	Баянцагаан багийн нэгдсэн байр	Баянцагаан баг Малчин баг
		Говил багийн нэгдсэн байр	Говил баг
6	Мөнхийн гэгээ	Даваат баг, Ундарга 1-1, өөрийн байранд	Даваат баг Шанд баг
			Наран багийн 11-75 дугаар гудамж
7	Нийцэл	Булаг баг, 1-р гудамж, өөрийн байранд	Булаг баг Баянбулаг баг
			Найрамдал баг Чандмань баг
8	Үйлсбадрах	Цагаанчулуут баг, төрийн үйлчилгээний нэг байр	Уртын гол баг Цагаанчулуут баг
			Наран багийн 1-10 дугаар гудамж Рашаант баг
9	Учралтбаяр	Эрдэнэ багийн нэгдсэн байр	Эрдэнэ баг Чингэл баг
		Дэнж баг, 40 тоот, өөрийн байранд	Дэнж баг
10	Энхжих мандариваа	Их залуу баг, их залуу багийн ард, өөрийн байранд	Яргуйт баг Баян-Овоот баг
			Их залуу баг